

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГ



ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2026 он

СУДАЛГААНЫ БАГ

АХЛАГЧ: Доктор (Ph.D), профессор Г.Алтанзаяа
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хүндэт Ерөнхийлөгч

ГИШҮҮД: Доктор (Ph.D) Ү.Галмандах
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Ерөнхийлөгч

Доктор (Ph.D), профессор Ч.Энхбаяр
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн “Татвар&Бизнес” сэтгүүлийн
редакцын зөвлөл, МУИС-ийн профессор

Доктор (Ph.D), профессор Б.Авирмэд
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Судалгааны менежментийн
хорооны дарга, СЭЗИС-ийн ахлах багш, профессор

Г.Хишигзул
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн Тамгын газрын дарга

НАРИЙН БИЧИГ: М.Мөнхнаран
Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн нягтлан бодогч

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	5
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ.....	5
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	5
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	6
2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	7
2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	7
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	7
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	8
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	9
3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	9
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал	10
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ.....	10
4.1. Үнэлэлт, дүгнэлт	10
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	15

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хүн амын худалдан авах чадварт нийцсэн, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна”, “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т татвартай холбоотой 17 чиглэл тусгагдсан байна.

Тус хөтөлбөрийн 3.2.1.2-т “Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна” гэж, мөн 3.2.1.4-т “..... Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална...” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 152 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4 дэх хэсгийн “Чинээлэг Монгол”-ын 1.10-т “Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ” гэж тус тус заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах хүрээнд бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх зорилтуудыг тусгасан.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зохицуулалтууд нь татварын тогтолцоог сайжруулах, бага, дунд орлоготой иргэдэд ирэх татварын ачааллыг бууруулах, тодорхой хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх замаар татварт хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийхэд оршино.

Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүрэгтэй¹. Татвар нь хүн бүрийн өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Хувь хүний орлогын албан татварын зорилго нь хувийн болон санхүүгийнхээ нөхцөл

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 17.1.3-р зүйл

байдалд тохирсон байхын зэрэгцээ татвараа үнэнч шударгаар төлөхөд чиглэх ёстой. Учир нь хувь хүний төлсөн татварын мөнгө улсын төсөвт төвлөрч, хүн амын боловсрол, эрүүл мэнд, улс орныг батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг сахиулах зэрэг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагддаг. Өөрөөр хэлбэл, хувь хүний төлсөн татвар эргээд ард иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулагдаж байна гэсэн үг юм. Иймээс иргэн бүр татвараа үнэн зөв тодорхойлж, цаг хугацаанд нь төлснөөр улс орны эдийн засгийг хөгжүүлэх, далд эдийн засгийг бууруулах, улмаар ард иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх, сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг хангах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Засгийн газартаа тусалж байна гэсэн үг.

Иймд “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл нь хувь хүний орлогын албан татварыг олон улсын жишигт нийцүүлэн ногдуулах, төлөх, тайлагнах харилцааг зохицуулах чухал хуулийн төсөл тул ач холбогдол өндөртэй хууль юм.

Монгол Улсад Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2019 оны 03 сарын 22-ны өдөр баталсан байдаг бөгөөд энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн. Тус хуульд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр, 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр, 2023 оны 11 сарын 10-ны өдөр, 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр буюу нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

“Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд дараах байдлаар өөрчлөлт оруулахаар тусгасан байна. Үүнд:

1. 1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын хуульд заалт нэмэх
2. 2 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах
3. 3 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулах
4. 4 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим хэсгийн үгийг хасах
5. 5 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох
6. 6 дугаар зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх хугацаа зэрэг болно.

Ийнхүү нийгмийн хэрэгцээ, шаардлага, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, санхүүгийн зах зээлийн өөрчлөлт, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилт, мөрдөлт зэргээс шалтгаалан нэмэлт, өөрчлөлтүүдийг цаг тухай бүрд нь хийжээ. Хувь хүний орлогын албан татварыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөн шинэчлэх шаардлага гарч буйг олон судалгааны бүтээл, илтгэл, нийтлэл, татвар төлөгчдийн хэлэлцүүлэг, мэргэжлийн байгууллагуудын өгсөн зөвлөмж, дүгнэлтэд авч үзжээ. Тиймээс энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааг дээрх нөхцөл байдлуудад нийцүүлэн хийсэн болно.

“Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ сонгох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонгосон бөгөөд зардал шалгуур үзүүлэлт хийгдсэн байсан тул орхисон болно.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал
5. Харилцан уялдаа

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Тухайлбал,

1. Хуулийн төсөлд тусгагдсан 1 дүгээр зүйлийн 15.9 дэх хэсэг нэмсүгэй, 3 дугаар зүйл Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай, 26 дугаар зүйл Тайланг урьдчилан боловсруулж хүргүүлэх, хялбаршуулсан горимоор тайлагнах, төлөх, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэгт зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
2. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн болон иргэдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэх;
3. Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу шинэ зохицуулалтууд нь хүлээн зөвшөөрөгдөх эсэх;
4. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгах.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй заалтын үр нөлөөг судална.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинэ хэлтэс, нэгж байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөө тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт бүрийг тус бүрд нь авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл, түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтуудыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Энэ хүрээнд дараах асуудлуудыг зорилгодоо нийцсэн эсэхийг авч үзнэ.

-Тус хуулийн төслийн зарим хэсэг нь Үндсэн хууль болон хуулийн төслийн 1.1-т заасан зорилгод нийцсэн эсэх

-Хуулийн төслийн зорилго нь Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйл Татварын үйл ажиллагаанд баримтлах зарчимд нийцсэн эсэх

Иймд “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслөөс дээрх асуудлын дагуу зорилгодоо хүрсэн эсэхийг “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг тооцно.

Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Хуулийн төслийн зорилго нь Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйл Татварын үйл ажиллагаанд баримтлах зарчимд нийцсэн эсэх	-Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Энэхүү хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тодорхой хэрэгцээ шаардлагын үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ².

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1.	Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлттэй холбоотой зохицуулалт	-Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт

² “Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд хийсэн үр нөлөө үнэлгээний тайлан, х.3

	9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх
--	---

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ.

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг. Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах, тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно³.

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд тухайн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэх байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэх учраас тодорхой байгууллага, иргэний эрх ашиг хөндөгдөж буй зохицуулалтыг сонгон авах нь зүйтэй байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн төслөөр зохицуулж буй, эсхүл шинээр бий болгож буй зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг үнэлэх учраас иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын эрх үүрэг, тэдгээрийн ашиг сонирхол хөндөгдөх зохицуулалтыг сонгон авдаг.

Тус хуулийн төслийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх зан суртахуун болон онолын хувьд хүлээн зөвшөөрөхгүй, нийтээр ижил ойлгох харилцааг өөр байдлаар зохицуулсан гэх зохицуулалтыг сонгон авлаа.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл заалт
1.	Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх байдал	-Хуулийн төслийн 23 дугаар зүйл 23.1. “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө.” Гэх

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

³ “Хувь хүний орлогын татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд хийсэн үр нөлөө үнэлгээний тайлан, х.3

Тохирох шалгах хэрэгсэл нь урьдчилан тогтоосон шалгуур үзүүлэлтээс шалтгаалан харилцан адилгүй байх бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрд нийцсэн дараах шалгах хэрэгсэл байна. Эдгээр шалгах хэрэгсэл нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтэд нийцсэн боломжтой арга, хэрэгсэл юм.

Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл
Зорилгод хүрэх байдал	Зорилгод дүн шинжилгээ хийх
Практикт хэрэгжих боломж	Практикт турших
Ойлгомжтой байдал	Ойлгомжтой байдлыг шалгах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх
Харилцан уялдаа	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	-Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх	Зорилгод дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих боломж	-Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх	Практикт хэрэгжих байдлыг баримт, бичигт дүн шинжилгээ хийх замаар хэрэгжих эсэхийг судлах
3.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	-Хуулийн төслийн 23 дугаар зүйл 23.1. “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө.” гэх	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд баримт бичгийн судалгаа хийж дүгнэх

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэлэв.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Зорилгод хүрэх байдал”-ыг үнэлэхдээ хуулийн үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэхээр тавьсан зорилгод хүрэх боломжтой байдлаар томъёологдож

чадсан эсэхийг тухайн хуулийн төслийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх

Энэхүү заалт нь бага орлоготой татвар төлөгчдийг дэмжих, татварын ачааллыг бууруулах, татварын тогтолцооны шударга байдлыг хангах зорилгод чиглэсэн бөгөөд эдгээр зорилгод хүрч байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж болно. Үүнд:

- 9,504,000 төгрөг хүртэлх орлоготой иргэдийг татвараас чөлөөлснөөр амьжиргааны баталгааг сайжруулж байна;
- Орлого багатай иргэдэд 100% хөнгөлөлт олгож буй нь татварын шударга байдлыг хангаж байна;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлэхийн тулд тайлан гаргах шаардлага нь татварын ёс зүй, тайлагналын соёлыг дэмжиж байна;
- Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт нь татварын албаны нөөцийг илүү үр дүнтэй чиглүүлэх боломжийг олгож байна;
- Хуулийн заалт нь зорилтот бүлэгт бодитоор хүрч байгаа эсэхийг статистик мэдээллээр үнэлэх боломжтой байна. Тус хуулийн төслийн зорилт нь хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөх, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Практикт хэрэгжих боломж” гэх шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүрээнд хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан зохицуулалтад дүн шинжилгээ хийнэ. Ингэхдээ баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх

Энэхүү хуулийн заалт нь татварын нийгмийн чиг баримжаатай бодлогыг хэрэгжүүлэх, бага орлоготой иргэдийг дэмжих, татварын шударга тогтолцоог бүрдүүлэх зорилготой. Үүнийг практикт хэрэгжих байдлаар үнэлэхэд дараах шалгуур үзүүлэлтүүд чухал үүрэгтэй. Үүнд:

- Хөнгөлөлт бодитоор хэрэгжиж, зорилтот бүлэгт хүрч байна;
- Тайлан гаргасан хувь хүний тоо, өмнөх онтой харьцуулахад өссөн байна;
- Хөнгөлөлт нь татварын албаны нөөцийг илүү үр дүнтэй чиглүүлэх боломжийг олгож байна;
- Иргэдийн орлого, зарцуулалтын бүтцэд эерэг өөрчлөлт үзүүлж байна.

3.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Тухайн хууль тогтоомжийн төсөлд хувь хүнд хүндрэл үүсгэх зохицуулалт байгаа тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож, хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгааг хийх нь зүйтэй. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн төслийн 23 дугаар зүйл 23.1 дэх заалт зохицуулалтад дүн шинжилгээг хийж “хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгсөн.

Хуулийн төслийн 23 дугаар зүйл 23.1. “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө.” гэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдалд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийсэн байдал

Энэхүү заалт нь бага орлоготой иргэдийг татварын дарамтаас чөлөөлөх зорилготой бөгөөд нийгмийн тэгш байдал, татварын шударга зарчимд нийцэх боломжтой. Гэвч хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалт, хяналт шаардлагатай байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдлын үнэлгээ

Нийгмийн тэгш байдал: Бага орлоготой иргэдэд татварын хөнгөлөлт олгож буй нь нийгмийн тэгш байдлыг дэмжиж байна.

Шударга байдал: Орлого багатай иргэд татвар төлөхгүй, харин өндөр орлоготой иргэд татвар төлөх нь шударга зарчимд нийцнэ.

Хууль зүйн зарчим: Тодорхой босго, шалгууртайгаар хөнгөлөлт олгож байгаа нь хууль зүйн тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломжийг хангаж чадаж байна.

Төсвийн орлого: Хөнгөлөлт олгосноор татварын орлого буурах магадлалтай ч нийгмийн үр өгөөжийг харгалзан үзэх шаардлагатай.

Татварын хяналт, ил тод байдал: Орлогоо үнэн зөв тайлагнасан эсэхэд хяналт тавих шаардлагатай.

Олон улсын жишиг: Олон улс оронд бага орлоготой иргэдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт олгодог практик байдаг. Жишээ нь, АНУ-д “standard deduction”, Европын орнуудад “tax-free threshold” гэх мэт.

Хуулийн төслийн энэхүү заалт нь нийгмийн тэгш байдал, татварын шударга зарчимд нийцэх боломжтой. Гэвч *хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалт, хяналт, тайлагналын ил тод байдал* хангагдаагүй тохиолдолд хууль эрх зүйн эрсдэл үүсэж болзошгүй гэж үзэж байна.

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

ДӨРӨВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх заалтын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээний хувьд дараах дүгнэлтийг өгч байна. Давуу талууд:

- **Нийгмийн эмзэг бүлгийг хамгаална:** Бага орлоготой иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлнэ.
- **Татварын бүртгэлд хамрагдах байдал нэмэгдэнэ:** Хөнгөлөлт авахын тулд тайлан гаргах шаардлага үүсэж, бүртгэл сайжирна.
- **Татварын шударга тогтолцоог дэмжинэ:** Орлого ихтэй иргэд илүү татвар төлж, орлого багатай иргэд хөнгөлөлт эдлэх боломжтой байна.

Сул талууд:

- **Орлогоо зориуд хэт доогуур тайлагнах эрсдэл:** Хөнгөлөлт авахын тулд орлогоо буруу тайлагнах тохиолдол гарч болзошгүй.
- **Хяналтын тогтолцоо шаардлагатай:** Орлогын бодит байдлыг шалгах механизм сул байвал зүй бус ашиглалт нэмэгдэнэ.
- **Төсвийн орлогод үзүүлэх нөлөө:** Хэт олон иргэн хөнгөлөлт эдэлбэл татварын орлого буурах магадлалтай.
- **Хуулийн 14, 15, 18 дугаар зүйлтэй уялдаа шаардлагатай:** Эдгээр зүйлээр орлого тодорхойлох аргачлал тодорхойгүй бол хөнгөлөлтийн хэрэгжилтэд саад учирч болзошгүй байна.

1. Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө” гэх заалтын практикт хэрэгжих байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнд дараах давуу болон сул талууд үүсэж болохоор байна.

Давуу талууд:

- **Иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлнэ:** Татварын хөнгөлөлт нь бага орлоготой иргэдийн санхүүгийн ачааллыг бууруулна.
- **Татварын бүртгэлд хамрагдах байдал нэмэгдэнэ:** Хөнгөлөлт авахын тулд тайлан гаргах, бүртгүүлэх сонирхол нэмэгдэнэ.
- **Нийгмийн тэгш байдлыг дэмжинэ:** Татварын хөнгөлөлт нь орлогын ялгааг тэнцвэржүүлэхэд тусална.

Сул талууд:

- **Орлогоо зориуд бууруулж тайлагнах эрсдэл:** Хөнгөлөлт авахын тулд зарим иргэн орлогоо хэт доогуур тайлагнаж болзошгүй.
- **Хяналтын тогтолцоо шаардлагатай:** Орлогын бодит байдлыг шалгах механизм сул байвал зүй бус ашиглалт гарна.
- **Төсвийн орлогод үзүүлэх нөлөө:** Хэт олон иргэн хөнгөлөлт эдэлбэл улсын төсвийн татварын орлого буурах магадлалтай.
- **Хуулийн 14, 15, 18 дугаар зүйлтэй уялдаа шаардлагатай:** Эдгээр зүйлээр орлого тодорхойлох аргачлал тодорхойгүй бол хөнгөлөлтийн хэрэгжилтэд саад учирна.

2. Ойлгомжтой байдлын шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн 23 дугаар зүйл 23.1. “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон тухайн жилийн нийт 9,504,000 хүртэлх төгрөгийн орлогод ногдуулах албан татварыг 100 хувь хөнгөлнө.” гэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдалд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараах давуу болон сул талууд байна.

Давуу талууд:

- **Нийгмийн зорилтот бүлгийг дэмжсэн бодлого:** 9.5 сая төгрөг буюу сард 800,000 төгрөгийн орлоготой иргэдийг татвараас чөлөөлөх нь бага орлоготой иргэдийн амьжиргааг дэмжих, тэгш байдлыг хангах зорилготой.
- **Татварын шударга тогтолцоог бүрдүүлнэ:** Орлого ихтэй иргэд илүү татвар төлж, бага орлоготой иргэд татварын хөнгөлөлт эдлэх нь татварын шатлалтай тогтолцооны зарчимд нийцнэ.
- **Тайлангийн соёлыг дэмжинэ:** Хөнгөлөлт эдлэхийн тулд орлогоо тайлагнах шаардлага үүсэх тул албан ёсны бүртгэл нэмэгдэнэ.
- **Олон улсын жишигтэй нийцнэ:** Хөгжингүй орнуудад бага орлоготой иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх нь нийтлэг практик юм.

Сул талууд:

- **Орлогоо зориуд бууруулж тайлагнах эрсдэл:** Хөнгөлөлт авахын тулд зарим иргэн орлогоо зориуд доогуур тайлагнах, эсвэл албан бус орлогоо нуух эрсдэлтэй.
- **Хяналтын тогтолцоо шаардлагатай:** Орлогын бодит байдлыг шалгах, хөнгөлөлт зүй бусаар ашиглагдахаас сэргийлэх хяналтын механизм сул бол хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө.
- **Төсвийн орлогод үзүүлэх нөлөө:** Хэт олон иргэн хөнгөлөлт эдэлбэл улсын төсвийн татварын орлого буурах магадлалтай.

Энэхүү заалт нь татварын шударга, хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн, хүлээн зөвшөөрөгдөх бодлогын зохицуулалт боловч хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалт, хяналт, төсвийн тэнцвэрт байдал зэрэгт анхаарах шаардлагатай байна. Зүй зохистой хэрэгжүүлбэл энэ заалт нь нийгмийн эмзэг бүлгийн амьжиргаанд бодит дэмжлэг үзүүлж чадахаар байна.

4.2. Зөвлөмж

“Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- **Тайлангийн хяналтын механизмыг тодорхой болгох:** Баталгаажсан тайлангийн шалгуур, хяналтын тогтолцоог нарийвчлах.
- **Хувь тогтоох уян хатан байдал:** Салбар, зардлын бүтэц, орлогын хэлбэрээс хамаарч хувь өөрчлөгдөх боломжийг судлах.
- **Хүсэлт гаргах журмыг тодорхой болгох:** Хүсэлт гаргах хугацаа, хэлбэр, шаардлагыг хуульд тусгах.

- **Мэдээллийн нэгдсэн санг сайжруулах:** Тайлангийн суурь мэдээлэл үнэн зөв байхын тулд НӨАТ, POS, банкны гүйлгээ зэрэг мэдээллийг уялдуулах.
- **Иргэдэд зориулсан сургалт, зөвлөмжийг нэмэгдүүлэх:** Хялбаршуулсан горимын талаар ойлголт өгөх, цахим тайлангийн хэрэглээг дэмжих.
- **Хяналтын тогтолцоог нарийвчлах:** Тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавих, эрсдэлтэй тохиолдолд нарийвчилсан шалгалт хийх.
- **Тайлангийн баталгаажуулалтыг автоматжуулах:** Иргэдийн баталгаажуулалтыг системээр хялбар болгох, сануулга өгөх.
- **Орлогын шалгуурыг нарийвчлах:** 9.5 сая төгрөгийн хязгаарыг салбар, бүс нутгийн онцлогоос хамаарч уян хатан болгох.
- **Хяналтын тогтолцоог сайжруулах:** POS, НӨАТ, банкны гүйлгээ зэрэг мэдээллийг уялдуулж орлогын бодит байдлыг хянах.
- **Хөнгөлөлт эдлэх журмыг тодорхой болгох:** Хэн, хэзээ, ямар нөхцөлөөр хөнгөлөлт эдлэхийг хуульд тодорхой тусгах.
- **Төсвийн нөлөөллийн тооцоолол хийх:** Хөнгөлөлтөөр алдагдах татварын хэмжээг урьдчилан тооцож, нөхөх арга хэмжээ авах.
- **Хөнгөлөлтийн дээд хэмжээг уян хатан болгох:** Орон сууцны үнийн өсөлт, бүс нутгийн ялгааг харгалзан хөнгөлөлтийн хэмжээг шинэчлэх.
- **Нэг удаагийн хязгаарлалт дээр уян хатан зохицуулалт хийх:** Орон сууцны нөхцөл эрс өөрчлөгдсөн тохиолдолд дахин хөнгөлөлт эдлэх боломжийг судлах.
- **Баримт нотолгооны шаардлагыг хялбаршуулах:** eBarimt, банкны гүйлгээ зэрэг цахим нотолгоог хүлээн зөвшөөрөх.
- **Хяналтын тогтолцоог сайжруулах:** Баримтын үнэн зөв байдлыг шалгах цахим систем, эрсдэлд суурилсан хяналт хэрэгжүүлэх.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- **Салбарын онцлогт нийцүүлэн хувь уян хатан болгох:** Зарим салбарт 10%-ийн татвар хэт өндөр байж болзошгүй тул хувь өөрчлөгдөх боломжийг судлах.
- **Тайлангийн хяналтыг сайжруулах:** POS, НӨАТ, банкны гүйлгээ зэрэг мэдээллийг уялдуулж тайлангийн үнэн зөв байдлыг баталгаажуулах.
- **Хүсэлт гаргах журмыг тодорхой болгох:** Хүсэлт гаргах хугацаа, хэлбэр, шаардлагыг хуульд тусгах.
- **Татварын хөнгөлөлтийн нөлөөллийн тооцоолол хийх:** Төсвийн орлогод үзүүлэх нөлөөг урьдчилан тооцож, зохицуулалт хийх.
- **Орлогын тодорхойлолтыг нарийвчлах:** Хуулийн 14, 15, 18 дугаар зүйлд орлогын төрөл, эх үүсвэр, тооцооллын аргачлалыг тодорхой тусгах.
- **Хяналтын тогтолцоог сайжруулах:** POS, НӨАТ, банкны гүйлгээ зэрэг мэдээллийг уялдуулж орлогын бодит байдлыг хянах.
- **Татварын хувь уян хатан байх боломжийг судлах:** Салбар, орлогын бүтэц, зардлын онцлогоос хамаарч хувь өөрчлөгдөх боломжийг нээх.
- **Иргэдэд зориулсан тайлбар, сургалт хэрэгжүүлэх:** Орлогоо зөв тайлагнах, татварын хувь тооцох талаар мэдээлэл олгох.
- **Орлогын шалгуурыг нарийвчлах:** 9.5 сая төгрөгийн хязгаарыг бүс нутгийн амьжиргааны түвшин, салбарын онцлогоос хамаарч уян хатан болгох.
- **Хөнгөлөлт эдлэх журмыг тодорхой болгох:** Хэн, хэзээ, ямар нөхцөлөөр хөнгөлөлт эдлэхийг хуульд тодорхой тусгах.
- **Төсвийн нөлөөллийн тооцоолол хийх:** Хөнгөлөлтөөр алдагдах татварын хэмжээг урьдчилан тооцож, нөхөх арга хэмжээ авах.
- **Нэг удаагийн хязгаарлалтад уян хатан хандлага хэрэглэх:** Гэнэтийн нөхцөл (жишээ нь, байгалийн гамшиг, гэр бүлийн өөрчлөлт) үүссэн тохиолдолд дахин хөнгөлөлт эдлэх боломжийг судлах.

- **Цахим баримт нотолгоог өргөнөөр хүлээн зөвшөөрөх:** eBarimt, банкны шилжүүлэг зэрэг цахим баримтыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх.
- **Хяналтын системийг сайжруулах:** Баримтын үнэн зөв байдлыг шалгах цахим хяналтын систем нэвтрүүлэх.
- **Хөнгөлөлтийн хэмжээнд доод, дээд хязгаар тогтоох:** Улсын хэмжээнд нэгдсэн хүрээ тогтоож, орон нутгийн шийдвэрийг тэр хүрээнд гаргах.
- **Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцыг стандартчилах:** Судалгаа, олон нийтийн оролцоонд суурилсан шийдвэр гаргах аргачлал боловсруулах.
- **Ил тод байдлыг хангах:** Хөнгөлөлтийн хэмжээ, үндэслэл, шийдвэр гаргах үйл явцыг цахим хэлбэрээр нийтэд мэдээлэх.
- **Хяналтын тогтолцоог нэвтрүүлэх:** Сангийн яам, Татварын ерөнхий газар орон нутгийн шийдвэрийг хянах, зөвлөмж өгөх эрхтэй байх.
- **Мэдээллийн эх үүсвэрийг уялдуулах:** НӨАТ, банкны гүйлгээ, хөдөлмөрийн гэрээ, даатгалын мэдээллийг нэгтгэж, тайлангийн суурь мэдээллийг баталгаажуулах.
- **Иргэдэд зориулсан сургалт, мэдээлэл түгээх:** Хялбаршуулсан горимын талаар ойлголт өгөх, цахим хэрэглээг дэмжих.
- **Тайлангийн баталгаажуулалтыг автоматжуулах:** Иргэдийн баталгаажуулалтыг системээр хялбар болгох, сануулга өгөх.
- **Эрсдэлд суурилсан хяналт хэрэгжүүлэх:** Өндөр эрсдэлтэй тохиолдолд нарийвчилсан шалгалт хийх.
- **Буцаан олголтын хугацааг тодорхой заах:** “30 хоногийн дотор” гэх мэт тодорхой хугацааны заалт оруулах.
- **Төсвийн санхүүжилтийн төлөвлөлтийг сайжруулах:** Илүү төлөлтийн буцаан олголтод зориулсан тусгай сан, төсөв батлах.
- **Цахим хяналтын систем нэвтрүүлэх:** Илүү төлөлтийн бүртгэл, шийдвэр, шилжүүлгийн явцыг цахимаар хянах боломж бүрдүүлэх.
- **Иргэдэд мэдээлэл өгөх, гомдол шийдвэрлэх механизм бий болгох:** Буцаан олголт хойшилсон тохиолдолд иргэд гомдол гаргах, хяналт тавих боломжтой байх.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
2. Татварын ерөнхий хууль, (2019)
3. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль (2019)
4. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015)
5. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

Монгол хэлээр:

1. НӨАТ-ын шинэчлэл, хэрэгжилтийн үр нөлөө – МУИС, Нягтлан бодох бүртгэлийн сэтгүүл journal.num.edu.mn

Цахим эх сурвалж

Монгол хэлээр:

1. Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/41096>